

Архангай аймаг дахь
төрийн аудитын газар



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН | 2020



АГУУЛГА

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УДИРДЛАГА, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ 2

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ 6

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ 11

НИЙЦЛИЙН АУДИТ 14

ДОТООД АЖИЛ 20

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ 24

ДҮГНЭЛТ, ЦААШДЫН ЗОРИЛТ 25

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Төрийн аудитын байгууллага 2020 оныг **Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин, стандартын шинэтгэлийн жил**” болгон зарласан.

Монгол улсын үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хүрээнд “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэж тусгасан нь Төрийн аудитын дээд байгууллагын үйл ажиллагааны хараат бус бие даасан байдлыг эрх зүйн орчны хэмжээнд баталгаажуулсан, олон улсын аудитын дээд байгууллагуудын шаардлагад бүрэн нийцсэн, аудитын хөгжил дэвшилд томоохон шинэчлэл хийгдсэн үйл явдал болсон юм.

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар шинэ эрх зүйн орчин бүрдсэн цаг дор 2020 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж байна.

Тайлангийн жилд Монгол улсын Ерөнхий аудиторын А/20 дугаар тушаалаар “Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин үнэлэх журам”-ууд батлагдсаны дагуу Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, гүйцэтгэлийг тайлагнаж ажиллаж ирлээ.

Төрийн аудитын газрын 2020 оны үндсэн үйл ажиллагаа болон түүний үр дүнг товч тоон үзүүлэлтээр харуулбал:

- Архангай аймаг дахь Төрийн аудитын газар ТАБ-ын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэн 4-н зорилтын хүрээнд 56-н арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсний 55-н арга хэмжээ буюу 98.2% нь бүрэн хэрэгжлээ.

	зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	хэрэгжүүлсэн арга хэмжээ	/тоогоор/
	Төрийн бодлого Төлөвлөлт Стандарт, арга зүй	3	3	
	Аудитын үйл ажиллагаа	27	26	
	хүний нөөцийн сургалт, сурталчилгаа	5	5	
	Дэмжих үйлчилгээ	21	21	
	Нийт	56	55	



Зорилт-1: Төрийн бодлого төлөвлөлт, стандарт арга зүй хүрээнд ТАГ-с дэвшүүлсэн 3-н зорилтоо 100% бүрэн хэрэгжүүлсэн байна. Үүнд :

- Тайлангийн жилд хийсэн аудит, судалгаанд тулгуурлан Монгол улсын зарим хууль, тогтоомж холбогдох заалтыг өөрчлөн шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах чиглэлээр Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг сайжруулах, цахим сайтын ашиглалтыг нэмэгдүүлэх чиглэлээр санал боловсруулан ажиллалаа.
- “Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан болон статистик мэдээг боловсруулах тайлагнах журам” -д аудитын шийдвэрийн хэрэгжилт, илрүүлэлтийг мэдээний нэг маягаар аудитын төрлөөр нэгтгэх загварыг боловсруулан саналыг СУГ-т хүргүүлээд байна.
- Төрийн аудитын газар 2021 онд гүйцэтгэх аудитын сэдвийн хүрээнд өөрсдийн хэмжээнд урьдчилсан үнэлгээ хийж, саналыг СУГ-т хүргүүлж ажиллалаа.

Зорилт-2: Аудитын үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн ажлын гүйцэтгэл 96.3% ийн гүйцэтгэлтэй байна. үүнд:

- Зорилтын хүрээнд санхүү, гүйцэтгэл, нийцлийн нийт 20-н аудит, аудиттай холбоотой 7-н ажлууд нийт 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 26-н ажлыг төлөвлөгөөт хугацаанд бүрэн гүйцэтгэн, 1 аудит цаг үеийн хөл хорионы дэглэм нөхцөл байдалтай уялдан хэрэгжих боломжгүй болсон юм.

Зорилт-3: Хүний нөөцийн , сургалт сурталчилгааны хүрээнд 5-н арга хэмжээ төлөвлөгдсөнийг 100% бүрэн хэрэгжүүлээд байна.

Зорилт-4: Аудитыг дэмжих үйлчилгээний хүрээнд төлөвлөгдсөн 21-н арга хэмжээг бүрэн 100% хэрэгжүүлсэн.

Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн орлогоос 25.0 сая төгрөгийг зарцуулах зөвшөөрөл өгсний дагуу байгууллагынхаа 2 ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэн, ажилчдынхаа ажиллах нөхцөл бололцоог сайжруулах үүднээс шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллалаа.


Төрийн аудитын газрын 2020 оны үндсэн үйл ажиллагаа, түүний үр дүнг товч тоон үзүүлэлтээр танилцуулбал:

- Тайлангийн жилд ТАГ нь санхүүгийн 161, гүйцэтгэлийн -8, нийцлийн -5, эрсдэлийн -2 нийт 176 аудит хийж аудитад нийт 499 хуулийн этгээдийг хамруулсан байна.
- Аудитаар 18419.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж үүнээс 4687.3 төгрөгийн үнийн дүн бүхий 99 алдаа зөрчлийг аудитын явцад залруулж бусад зөрчлийг залруулахаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгсөн байна.



- *Төрийн аудитын газар 2020 онд 11929.4 сая төгрөгийн үр өгөөжийг аудитад хамрагдсан байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн нь төсвийн “Нэг” төгрөгийн санхүүжилт тутамд 26 төгрөгийн үр өгөөжийг бий болгосон байна.*

Төлбөрийн акт: Тайлант жилд 124.1 сая төгрөгийн 93 төлбөрийн акт тогтоосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.3 дахин өссөн байна. Тайлант хугацаанд өмнөх оны болон тайлангийн хугацааны нийт 131.6 сая төгрөгийн 98-н төлбөрийн актыг барагдуулж 89% ийн хэрэгжилтэй, өмнөх оны 2.0 сая төгрөгийн 1 актыг хуулийн байгууллагад шилжүүлэн, 12.4 сая төгрөгийн 2 актыг хэрэгжих хугацаа болоогүй дүнтэй байна.



Албан шаардлага: Тайлангийн хугацаанд 8593.7 сая төгрөгийн зөрчил арилгуулах 139 албан шаардлагыг шалгагдагч байгууллагад хүргүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 28.9% иар өссөн юм. Өмнөх оны болон тайлангийн хугацааны нийт **12654.7** сая төгрөгийн 143-н албан шаардлагаас **7514.0** сая төгрөгийн 119 албан шаардлагыг тайлангийн хугацаанд барагдуулжээ. Тайлант онд өгсөн **4193.6** сая төгрөгийн 18-н албан шаардлагын хэрэгжих хугацаа болоогүй дүнтэй байна.



Жилийн эцэст төсөвт байгууллагуудын урсгал зардал танагдсан, зарим байгууллагуудад их хэмжээний урьд оны болон тайлангийн жилийн өр нэмэгдсэн цаг үеийн нөхцөл байдал хөл хорионы дэглэмтэй холбоотой зарим байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө тасарсан зэргээс үүдэж манай байгууллагаас хүргүүлсэн албан шаардлагын хэрэгжилтэд шалгагдагч нараас хүсэлт тайлбарууд ирүүлсний дүнд Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэрээр **төсөвт байгууллагын өр, авлага, өөрийн орлогын төвлөрүүлэлт тасарч байгаатай холбоотой 947.1** сая төгрөгийн 6-н албан шаардлагыг мэдээний дүнгээс хасаж тооцлоо.



Зөвлөмж: Төрийн аудитын газраас тайлангийн жилд хийсэн аудитаас нийт 4980.7 сая төгрөгийн 210 зөвлөмж хүргүүлж өмнөх оны нийт 218 зөвлөмжийн 85.8% буюу 4980.7 сая төгрөгийн 187 зөвлөмж бүрэн хэрэгжиж, оны сүүлийн хагаст хийгдсэн нэгдсэн төлөвлөгөөт “Орон нутгийн хөгжлийн сан”, Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал” гүйцэтгэлийн аудитуудаас өгсөн 31-н зөвлөмжийн хэрэгжих хугацаа болоогүй буюу он дамнахаар үлдэгдэлтэй байна.



Нийт зөвлөмжийн 48.6 хувийг санхүүгийн аудитаар хууль тогтоомжийн хэрэгжилттэй, 10.5 хувийг аривлан хэмнэлт, үр ашигт, 16.7 хувийг нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой, 9.5 хувийг орлого бүрдүүлэлт төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой, 11 хувийг худалдан авалт, дотоод хяналттай, 3.7 хувийг хөрөнгийн зориулалт бус зарцуулалттай холбоотой зөрчлүүдэд өгсөн байна.

Санхүү, гүйцэтгэлийн аудитаар тайлангийн хугацаанд зөрчил гаргасан 19-н албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлэн биелэлтийг бүрэн хангууллаа. *Аудитаас шинээр 35.2 сая төгрөгтэй холбоотой 3-н асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, өмнөх оны үлдэгдэл 987.0 сая төгрөгийн 6 асуудал нийт 1022.2 сая төгрөгийн 9-н асуудлаас тайлангийн жилд 804.0 сая төгрөгийн 2 асуудал бүрэн шийдвэрлэгдэж, 153.4 сая төгрөгийн 5 асуудал хянагдаж, 64.8 сая төгрөгийн 2 асуудал хэрэгсэхгүй болсон байна.*



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар нь тайлангийн жилд Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан “ Аймаг нийслэл дэх төрийн аудитын газрын бүтэц батлах тухай тушаал”-ын дагуу 12 орон тоотой ажиллахаас 13 орон тоогоор санхүү, гүйцэтгэл, нийцлийн баг дэмжих үйлчилгээ гэсэн бүтэц зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж ирлээ.

БАТЛАГДСАН ОРОН ТОО - 12

ГҮЙЦЭТГЭЛ -13

Нийт ажиллагсдын 76.9% нь эдийн засагч, нягтлан бодогчийн мэргэжилтэйгээс 50% нь Мэргэшсэн нягтлан бодогчид байна.



Тайлангийн жилд хамт олны хурал 3, Удирдлагын зөвлөлийн хурал 11 удаа хуралдаж 22 асуудлыг хэлэлцсэнээс аудитын тайлан дүнтэй холбоотой 11, санхүү төсөв, бусад асуудалтай холбоотой 11 асуудлыг тус тус хэлэлцэн холбогдох шийдвэрүүдийг гаргалаа. Аудиторуудын ажлын гүйцэтгэл, үр дүнг журмын дагуу хагас бүтэн жилээр үнэллээ.

2020 оны хийсэн санхүүгийн аудитаар 167 тайлан, гүйцэтгэл нийцлийн аудитын 48 нийт 215 тайланг шалгагдагч байгууллага болон холбоотой талуудад хүргүүлсэн байна. Төрийн аудитын газрын ажилтнуудыг Төрийн аудитын байгууллагын 2020 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан “Төрийн аудитын хуулийн хэрэглээ” онлайн сургалтад бүрэн хамруулан шалгалтад хамт олноороо 90 дээш хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдлээ. Албан бичиг хөтлөлтийн ABLE программыг байгууллагын хэмжээнд бүрэн дүүрэн ашиглаж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ


Архангай аймаг дахь Төрийн аудитын газар 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу санхүүгийн тайлангийн аудитаар улс, орон нутгийн төсөвт байгууллага, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл сан, Орон нутгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартад нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэхийг баталгаажууллаа.

Аудитыг Монгол Улсын Ерөнхий Аудиторын А/60 дугаар тушаалаар батлагдсан бүх шатны төсөв захирагчдын тайланд Төрийн аудитын хуулиар тодорхойлсон чиг үүргийнхээ хүрээнд 250 байгууллагын санхүүгийн тайланг аудитад хамруулсны 17 төсөв захирагчийн тайланд итгэл үзүүлж, 72 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан, 161 байгууллагын санхүүгийн тайланд санал дүгнэлтийг хүргүүллээ.






Аудитын санал дүгнэлтийн 142 буюу 88.2% “Зөрчилгүй”, 15 буюу 9.3% нь Хязгаарлалттай, 4 буюу 2.5% нь татгалзсан дүгнэлт өгсөн нь өмнөх онтой харьцуулахад хязгаарлалттай санал дүгнэлтийн тоо 8-аар, татгалзсан санал дүгнэлтийн тоо 1-ээр нэмэгдсэн, зөрчилгүй санал дүгнэлтийн тоо 11-ээр буурсан байна.



Төрийн аудитын газар санхүүгийн тайлангийн аудитаар нийт **12002.0** сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс **4687.3** сая төгрөгийн алдаа зөрчлийг санхүүгийн тайланд залруулсан байна. Аудитаар залруулагдаагүй **7314.7** сая төгрөгийн алдаа зөрчлөөс 88 зөрчилд **101.7** сая төгрөгийн төлбөрийн акт, 102 зөрчилд **2306.8** сая төгрөгийн албан шаардлага өгч, **4873.0** сая төгрөгийн 129 зөрчилд зөвлөмж, **33.2** сая төгрөгийн 2 асуудлыг хуулийн байгууллагад шилжүүллээ. Аудитаар алдаа зөрчил гаргасан 17 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлснээс 11 санал хэрэгжсэн байна.



Төлбөрийн актны хэрэгжилтийн талаар: Тайлант хугацаанд тогтоосон **101.7** сая төгрөгийн **88** төлбөрийн актыг тогтоон, хэрэгжилтийг бүрэн хангуулан ажиллалаа.



Албан шаардлагын хэрэгжилтийн талаар: Аудитаар нийт **2,306.8** сая төгрөгийн зөрчлийг арилгуулах, таслан зогсоох **102** албан шаардлага хүргүүлэн **1,575.8** сая төгрөгийн **98** албан шаардлагын биелэлтийг хангуулж, биелэлт **68.3** хувьтай байгаа бөгөөд **72.0** сая төгрөгийн **1** албан шаардлагын хугацаа болоогүй хэрэгжих шатандаа байна. Харин өмнөх оны **132.0** сая төгрөгийн өр авлага барагдуулах **2**, тайлант оны **658.9** сая төгрөгийн өр барагдуулах болон орлогын төлөвлөгөөг хангаж ажиллах **3** албан шаардлага нь цар тахал үүссэн энэ оны онцлог нөхцөл байдалтай холбоотойгоор биелэх боломжгүй болсон тул, энэ



асуудлыг УЗХ-аар хэлэлцүүлэн статистик мэдээнээс хасаж шийдвэрлэсэн.

Зөвлөмжийн биелэлтийн талаар:

Аудитаас **4,873.0** сая төгрөгийн зөрчилд үйл ажиллагааг сайжруулах, алдаа зөрчлийг засаж залруулах чиглэлээр **129** зөвлөмжийг хүргүүлэн, биелэлтийг бүрэн хангуулан ажиллалаа.




Санхүүгийн тайлангийн аудитын дүнг төсөв захирагчдаар танилцуулбал:

ОРОН НУТГИЙН ТЕЗ-ЧИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, Төсвийн тухай хуулийн 8.9.4 дэх заалтын дагуу аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд аудит хийж хуульд заасан хугацаанд ТЕЗ болон УАГ-т хүргүүллээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд сумдын төрийн сангийн нэгтгэсэн 19 тайлан, төсвийн шууд захирагчдын 156, төсөл сангийн 41, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 4 нийт 220 санхүүгийн тайланг нэгтгэсэн бөгөөд орон нутгийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээ, халамжийн сан, мал хамгаалах сангийн зардлын данс, ахмадын хорооны санхүүгийн дэмжлэг зэрэг зардлын данстын гүйлгээ хамрагдлаа.

Аудитаар нийт **808.8** сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад **10.0** сая төгрөгийн алдааг залруулж, **147.9** сая төгрөгийн алдаа, зөрчилд албан шаардлага хүргүүлж, 650.9 сая төгрөгийн 3 алдаа, зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлж биелэлтийг бүрэн хангууллаа.



ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад илэрсэн алдаа зөрчлийг үнэлж, аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд **“Зөрчилгүй”** санал дүгнэлтийг өгч, аудитын дүнд үндэслэн төсөвт байгууллагын санхүүгийн тайлагнал, тодруулга, бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөх, Төсвийн тухай хуулийг мөрдөн өр авлагагүй ажиллах, ОНӨҮГ-уудын үр дүн, ашигт ажиллагааг дээшлүүлэх 3 заалт бүхий зөвлөмжийг аймгийн Засаг Даргад хүргүүллээ.

НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ



Төсвийн тухай хуулийн 8.9.4 дэх заалтын дагуу Төсвийн Ерөнхийлөн захирагчаас тайлагнасан Орон нутгийн ТЕЗ ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан нийт орлого ба тусламжийн 68709.9 сая төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн 67934.3 сая төгрөгийн гүйцэтгэлийг баталгаажууллаа.

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар нийт **344.9** сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 170.4 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 66.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 108.3 сая төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж хүргүүлж биелэлтийг бүрэн хангууллаа.



СУМДЫН ТЕЗ-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төсвийн тухай хуулийн 8.9.2 дахь заалт, Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд 19-н сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд аудит хийж, 17 сумын тайланд “Зөрчилгүй, 2 сумын тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг хүргүүллээ.

Аудитаар орон нутгийн төсвийн орлогыг нэр төрлөөр жигд ханган биелүүлээгүй, СХС-ийн зээлийн эргэн төлөлт удааширсан, хугацаа хэтэрсэн зээлийн талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт **5,720.4** сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад **1,233.9** сая төгрөгийн алдааг залруулж, **1,257.6** сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, **3,228.9** сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч ажиллалаа.



ТУСГАЙ САНГИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитад Халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Нийгмийн даатгалын 3 сангийн санхүүгийн тайлан хамрагдаж Зөрчилгүй санал дүгнэлт гаргалаа. Харин аймгийн Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан, аймгийн эрсдэлээс хамгаалах сангийн 40 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгалаа. Аудитаар НДСантай холбоотой 2019 оны урсгал үйл ажиллагааны зардлын батлагдсан төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 2.9 сая төгрөгийг ахмадын сангийн дансанд төвлөрүүлсэн зөрчил илэрсэнд аудитаас зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэн биелэлтийг хангууллаа.

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалтын дагуу хийгдсэн санхүүгийн тайлангийн аудитад улсын төсвийн 25, орон нутгийн төсвийн 156 нийт 181 төсвийн шууд захирагчдын тайлан аудитад хамрагдсанаас 17 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 31 тайланг түүвэрт хамруулан, 133 төсөв захирагчийн тайланд санал дүгнэлт гаргалаа. Аудитаас гаргасан нийт дүгнэлтийн 121 төсөв захирагчийн тайланд “Зөрчилгүй”, 10 төсөв захирагчийн тайланд “Хязгаарлалттай”, 2 төсөв захирагчийн тайланд “Санал дүгнэлт өгөхөөс татгалзлаа”.

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар нийт **4,415.7** сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад **3,106.1** сая төгрөгийн алдааг залруулж, **101.7** сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **601.5** сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, **573.2** сая төгрөгийн 89 зөрчилд зөвлөмж хүргүүлж биелэлтийг 100% хангуулж ажиллалаа. Харин **33.2** сая төгрөгийн 2 асуудлыг УАГ-ын хууль эрх зүйн хэлтэс болон аймгийн Цагдаагийн газарт хянуулахаар шилжүүлснээс 29.7 сая төгрөгийн асуудлыг хэрэгсэхгүй болгон, 3.5 сая төгрөгийн асуудал хянагдах шатандаа байна.



ТБОНӨААН-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төсвийн тухай хуулийн 8.9.8 дахь заалт, Төрийн аудитын бүрэн эрхийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчит 5 хуулийн этгээдийн санхүүгийн тайланд аудит хийхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 6 тайланг хамруулан, 5-н тайланд аудит хийж дүгнэлт гарган, 1 тайланг түүврийн аргаар шалгалаа. Аудит хийж бие даасан дүгнэлт өгөх хуулийн этгээдийн 3 тайланд “Хязгаарлалттай”, 2 тайланд санал дүгнэлт өгөхөөс татгалзлаа.

Аудитаар нийт **712.3** сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад **166.9** сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, **233.7** сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, **311.7** сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж биелэлтийг 100% хангуулсан байна.



ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

ТАГ 2020 онд баталсан аудитын сэдэв, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд гүйцэтгэлийн 8 аудит хийхээр төлөвлөснөөс 7 аудитыг бүрэн хийж, өөрийн санаачилгаар “ Байгаль хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаанд зориулан төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын үр дүн”-д аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэж байна. Гүйцэтгэлийн аудитад 17 хүн/ *давхардсан тоогоор*/ нийт 179 өдөр зарцуулж 282 илүү цаг ажиллан 46.8 сая төгрөг зарцуулсан байна. Тайлант хугацаанд гүйцэтгэсэн аудитад давхардсан тоогоор төсвийн 106 байгууллага, тэдгээртэй холбогдох талуудын үйл ажиллагааг хамруулан шалгалаа.



Аудитаар нийт **2189.6** сая төгрөгийн зөрчил илрүүлж зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргахгүй, таслан зогсоох 2079.7 сая төгрөгийн 18 албан шаардлага хүргүүлж биелэлт 100%, 22.0 сая төгрөгийн 4-н төлбөрийн акт тогтоосны 45.4 буюу 10.0 сая төгрөгийг төвлөрүүлж, 12.0 сая төгрөгийн 2 төлбөрийн актны хэрэгжих хугацаа болоогүй дараа онд биелэгдэхээр байна.



Аудитаар өмнөх зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах 2 санал, илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй, үр ашигтай арга хэмжээ авч хэрэгжүүлэх 61 заалт бүхий 87.9 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлснээс 43 зөвлөмжийн биелэлтийг бүрэн хангуулсан байна.



Өмнөх онд нэгдсэн төлөвлөгөөний дагуу хийгдсэн Сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаатай холбоотой аудитаас өгсөн 6 зөвлөмж, 5.5 сая төгрөгийн 4-н төлбөрийн акт бүрэн хэрэгжсэн бол 2.0 сая төгрөгийн төлбөрийн актыг Цагдаагийн байгууллагад шилжүүллээ.



Тайлангийн хугацаанд өмнөх онд хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн 976.9 сая төгрөгийн 5 асуудлаас Хашаат, Өлзийт, Цэцэрлэг сумдад шинээр баригдаж буй соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэгч нарт бодит гүйцэтгэлд ногдохоос илүү санхүүжилт тооцож олгосон 793.9 сая төгрөгийн, Жаргалант сумын ЕБС-ийн 35.1 сая төгрөгийн зөрчлүүдийг эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж Прокурорын тогтоолоор гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж хааж



шийдвэрлэсэн байна. Тайлангийн жилийн эцэст нийт 149.9 сая төгрөгийн 4-н асуудал хянагдаж байна.

Тайлангийн хугацаанд гүйцэтгэсэн аудитын үр дүнд нийт 2177.6 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг шалгагдагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн байна.

НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ:

❖ УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ"-Т ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

2019 онд Архангай аймгийн Засаг даргад Төсвийн ерөнхийлөн захирагч нараас Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан 121,010.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, тухайн онд санхүүжих 33,730.0 төгрөгийн дүн бүхий 46 төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлсний 12 ТАХ нь он дамжих барилга угсралтын, 34 ТАХ нь тайлант онд ашиглалтад бүрэн орохоор эрх шилжин ирж төлөвлөгджээ.

Аудитын дүнгээс гэрээний хугацаа хэтрүүлсэн, ТАХ-г дутуу, чанаргүй хийсэн **978.5** сая төгрөгийн зөрчлийг гүйцэтгэгч нараар арилгуулах, **295.4** сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч ашиглалтыг эхлүүлж хөрөнгө оруулалтын үр ашгийг бий болгоход чиглэсэн 4 албан шаардлага, аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй, үр дүнтэй арга хэмжээ авах 12 заалт бүхий зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж биелэлтийг бүрэн хангуулаад байна. Аудитаас орон нутагт эрх шилжүүлсэн ТАХ-ний санхүүжилтэд хяналт тавих эрхийг хамт шилжүүлэх саналыг ТЕЗ нарт хүргүүлэхээр ҮАГ-т уламжилж ажилласан.

❖ ТӨРӨӨС БҮХ НИЙТИЙН БОЛОВСРОЛ ОЛГОЖ БАЙГАА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ҮР ДҮН, ҮР АШИГ

Гүйцэтгэлийн аудитын нэгдсэн төлөвлөгөөний дагуу аймгийн БСУГ, ЗДТГ, төрийн өмчийн 18 сургуулийн 2016-2019 оны үйл ажиллагааг хамруулан аудитыг гүйцэтгэлээ. Аудитаар аймаг, сумын ИТХ-аас төрийн өмчийн сургуулийг хөгжүүлэх төлөвлөгөө баталж мөрдүүлээгүй, сургуулийн хэв, шинж, байршлаас хамааран суралцагчийн тоо харилцан адилгүй, багийн сургуулиудын анги дүүргэлт хангалтгүй, сургуулийн дотоод, гадаад орчны аюулгүй байдлыг бүрэн хангаагүй, дуу хөгжмийн багш, мэргэжлийн номын санч дутагдалтай боловсролын үнэлгээний төвөөс сурлагын чанарт жил бүр үнэлгээ хийж байгаа боловч чанарыг дээшлүүлэх талаар ямар нэг зөвлөмж өгөөгүй, БСУГаас хяналт шалгалтын үр нөлөөг үнэлээгүй, эцэг эхийн зөвлөлийн хяналтыг бүрэн хэрэгжүүлж олон нийтийг мэдээллээр хангаагүй зэрэг зөрчлүүд илэрлээ.



Аудитаас **“Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний зорилго, зорилт бүрэн хангагдаагүй байна”** гэсэн дүгнэлт өгсөн.

Аудитаас аймгийн ИТХ-ын даргад төрийн өмчийн сургуулиудыг хөгжүүлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулах, аймгийн Засаг даргад ерөнхий боловсролын сургуулийн орчны стандартыг хангах, зориулалтын барилгаар хангах, багийн сургуулиудын талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг судалж шийдвэрлэх холбогдох арга хэмжээг авах зөвлөмжийг хүргүүлсэн. Мөн БСУГ-ын даргад нийт 13 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсний биелэгдэх хугацаа болоогүй бөгөөд дараа онд хэрэгжихээр байна. Аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлснээр шаардлага хангасан сургалтын орчин, мэргэжлийн боловсон хүчнээр хангагдах, сургалтын хөтөлбөр төлөвлөгөө жигд хангагдаж сурлагын чанар дээшлэх зэрэг бүх нийтийн ерөнхий боловсрол олгох үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлсэн үр өгөөж бий болно гэж үзэж байна.

Харин албан шаардлагын хэрэгжилтийг хангуулсан бөгөөд үүний үр дүнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх үр дүн бий болгоод байна.

❖ СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

УИХ-ын 2020 оны сонгууль зохион байгуулахтай холбогдсон батлагдсан төсвийг Архангай аймгийн сонгуулийн хороо хууль журмын дагуу хэсгийн хороодод хуваарилж, зарцуулжээ. Улсын төсвөөс аймгийн Сонгуулийн хороонд сонгууль зохион байгуулахтай холбогдуулан нийт 558,391.0 мянган төгрөгийн санхүүжилт ирсэн байна. Үүнээс 428503.5 мянган төгрөг буюу 77.7 хувийг сумын сонгуулийн хороонд, 129887.5 мянган төгрөг буюу 22.3 хувийг аймгийн сонгуулийн хорооны үйл ажиллагаанд зарцуулахаар тус тус хуваарилан, зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулсан байна. Нийт зардлын 66.1 хувийг сонгуулийн байгууллагын ажилтны мөнгөн урамшуулалд, 10.9 хувийг унааны зардалд, үлдэх 23 хувийг бусад урсгал зардалд зарцуулсан байна. Аудитаас **“УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу хуваарилж, зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан байна”** гэсэн нэгдсэн дүгнэлт өгсөн.

❖ ОРОН НУТГИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ЖИЛИЙН ХУГАЦААНД ТУХАЙН НАМД ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ӨГСӨН ХАНДИВЫГ ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛАХ

Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцох улс төрийн намуудын сонгуулийн жилийн 06 сарын 01-нээс өмнөх жилийн 01 сарын 01-нийг хүртэл хугацаанд хүлээн авсан хандивын тайланг хянаж баталгаажуулах ажлыг 2020 оны 06 сарын 18-наас 08 сарын 04-ний хооронд хэрэгжүүлсэн. Сонгуульд оролцох улс төрийн 5 намаас ирүүлсэн хандивын тайланг хүлээн авч холбогдох хууль, МУЕА-ын 2020 оны 06 сарын 02-ны өдрийн А/47 тушаалын хавсралтаар



баталсан зааврын дагуу хянаж баталгаажуулан, дүгнэлтийг улс төрийн нам тус бүрт хүргүүлсэн.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙЦЛИЙН АУДИТ

Төрийн аудитын байгууллагын 2020 онд нэгдсэн төлөвлөгөөний дагуу “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”, Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт -д аудитыг хийж 2 хүн оролцож, гүйцэтгэлээ.

ТАГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг журамд нийцүүлэн зарцуулсан эсэх” зэрэг 5 аудитыг хугацаанд нь дуусгаж, аймгийн ИТХ-ын захиалгат “Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, байдал”-д хийх аудитыг цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан дараа онд шилжүүлэн гүйцэтгэхээр боллоо.

АНИТХСТХууль, МУЕА-ын 2020 оны “А/52 дугаар тушаал “ Аймаг нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аргачлал”-ын дагуу зардлын дээд хэмжээ тогтоох ажил, “Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах” ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн бол “Аймаг, сумын ИТХ-д оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх” аудит гүйцэтгэлийн шатандаа явж байна.

2020 онд гүйцэтгэсэн нийцлийн аудитаар нийт **4227.4** сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 19 зөрчилд 4207.2 сая төгрөгийн албан шаардлага өгч, 0.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 19.8 сая төгрөгийн 20 зөрчилд зөвлөмж, хүргүүлснээс 105.4 сая төгрөгийн 1, албан шаардлага, 5-н зөвлөмж хэрэгжиж, ОНХСангийн аудитын 4121.6 сая төгрөгийн албан шаардлага, төлбөрийн акт нь дараа онд хэрэгжихээр байна.

Тайлант хугацаанд өөрийн санаачилгаар хийсэн Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын 85.6 сая төгрөгийн, өмнөх оны Худалдан авах ажиллагааны хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын 3772.9 сая төгрөгийн нийт 3858.6 сая төгрөгийн 2 албан шаардлага, 2 зөвлөмжийн биелэлт бүрэн хангагдлаа.

➤ ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТ



Тайлангийн хугацаанд хийсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-ийн аудитад нийт 172 байгууллага, хуулийн этгээдийг хамруулан, 2 хүн 52 өдөр зарцуулж 237 илүү цаг ажилласан байна. Аудит хийж байгаа цаг үед Улсын хэмжээнд хорио цээрийн дэглэм тогтоосон байсан тул Улсын Онцгой комисс, ЭМЯ-ны зөвлөмжийн дагуу Шилэн дансны аудитын нээлт, төлөвлөгөөг аймаг, сумдын төсөв захирагч, нягтлан бодогч нарт цахимаар бэлтгэн 213 албан тушаалтанд аудитын төлөвлөгөөг танилцууллаа. Аудитаар илэрсэн зөрчлийг аймаг, сумдын удирдлага, холбогдох албан тушаалтнуудад онлайнаар танилцуулахын зэрэгцээ цахим сайттай ажиллахад гарч байгаа хүндрэл бэрхшээл, цаашид сайжруулах



саналыг эрх бүхий албан тушаалтнуудаас саналыг онлайнаар авч нэгтгэн үнэлж, саналыг холбогдох төрийн захиргааны эрх бүхий байгууллагад хүргүүлэхээр тайланд тусгалаа. Мөн хуулийн хэрэгжилт, түүнд тавих дотоод хяналт, жил бүр давтамжтай хийгдэж байгаа аудитын үр нөлөөг сайжруулах үүднээс хууль, журмын зүйл, заалтыг боловсронгуй болгож өөрчлөх 8 саналыг НАГ-т уламжиллаа.

Аудитаас **Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 79.6 хувьтай байна** гэсэн дүгнэлтийг хийж, хэрэгжилтэд хөндлөнгийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, цахим системд бүртгэлгүй хуулийн этгээдийг бүртгэлжүүлэх асуудлын хүрээнд 2 зөвлөмж, аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, шилэн дансны цахим сайтад мэдээллийг үнэн зөв, иж бүрэн, хугацаа хоцролгүй байршуулж ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэн биелэлтийг хангууллаа.

➤ **ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН АУДИТ**

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн нийцлийн аудитад “zoom” программ ашиглан сумдтай нэгдсэн байдлаар **онлайнаар холбогдож аудитын нээлтийг хийж** төлөвлөгөө, хөтөлбөр, шаардлагатай судалгаа, мэдээлэл, санал асуулгыг танилцуулж, аудитын явцад анхаарах асуудлын талаар ярилцаж, харилцан санал солилцож ажиллалаа. Энэ нь хүний нөөцийн хүрэлцээгүй, ажлын ачаалал их байгаа үед цаг хугацаа, төсөв хөрөнгө хэмнэсэн үр дүнтэй ажил боллоо. 2019 онд Аймгийн хэмжээний нийт **172** төсөл арга хэмжээний **5,376.3** сая төгрөгийн зарцуулалтыг шалгалаа.

Аудитаар орон нутгийн иргэдийн санал, олон нийтийн хэлэлцүүлэг, нийтийн эрх ашигт нийцсэн нэгдсэн жагсаалтад үндэслэн төлөвлөгдөөгүй 3,581.7 сая төгрөгийн, худалдан авах ажиллагааны хууль, журам зөрчсөн 535.1 сая төгрөгийн, зориулалт бус зарцуулсан 5.2 сая төгрөгийн нийт **4,122.0** сая төгрөгийн зөрчил илэрсэнд аудитаас зөрчил арилгуулах 17 албан шаардлага, төлбөрийн акт-1, аймаг, сумдын ИТХ-ын болон засаг дарга нарт 13 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлж биелэлтийн хугацаа болоогүй дүнтэй байна.

Цаг үе, хорио цээрийн дэглэмийн улмаас богиносгосон цагаар болон цахимаар гэрээсээ ажиллах, бусдыг хөдөлгөөнд оролцуулах аливаа асуудал үүсгэхгүй байх зэрэг нөхцөл шаардлагын улмаас зарим нэг аудит цаг хугацаандаа хийгдэхгүй байх, сунжрах зэрэг хүндрэл тохиолдсон.

- **АНСДИТХСТХуулийн 37.5 “Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн**

- **тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар:**

Аймаг, нийслэл сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн дагуу Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас аймгийн МАН, АН, МАХН, ШИНЭ нам, Хөдөлмөрийн үндэсний нам, Иргэний хөдөлгөөний нам нийт 6-н нам, 2 бие даан нэр дэвшигчийн нийт 64 мөрийн хөтөлбөрийг хянаж хуулийн хугацаанд дүгнэлтийг гаргаж аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлж, сайтад байршуулж ажиллалаа.


Сонгуулийн хуулийн дагуу орон нутгийн сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянах гүйцэтгэлийн үе шатны ажил эхлээд байгаа тул тухайн аудитыг дараа онд шилжүүлэн хийхээр ҮАГ-т уламжилсан болно.

ТАВДУГААР БҮЛЭГ. ӨӨРИЙН САНААЧИЛГААР ХИЙСЭН АУДИТЫН ТАЛААР

2020 онд Төрийн аудитын газар нь сонгуулийн хуулийн дагуу Аймаг, нийслэл сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох” тооцооны ажлыг бүрэн хийж гүйцэтгэлээ.

Тайлант жилд хийгдсэн аудитын товч танилцуулъя.

- **“ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР АШИГ, ҮР НӨЛӨӨ” -АУДИТ**



Аудитад 2 хүн 23 өдөр зарцуулж, 8-н байгууллагыг хамруулан 28 цаг илүү ажилласан байна. Аудитаас аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим төсөл арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, зорилтод түвшинг хангаагүй нь төлөвлөлтийг бодлогын баримт бичигтэй уялдуулаагүй, хэрэгцээ шаардлагыг тооцоогүй, зураг төсвийг хийдэггүй холбоотой байна гэж дүгнэлээ.

Аудитын дүнд үндэслэн хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн журмын хэрэгжилтийг хангуулах 443.8 сая төгрөгийн 4 албан шаардлагыг аймгийн ГХБХБГ болон ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлснээс 64.8 сая төгрөгийн 2 албан шаардлагын хэрэгжилтийг хангуулж, 379.0 сая төгрөгийн 2 албан шаардлагын хэрэгжилтийн хугацаа болоогүй дүнтэй байна. Аудитаас үүрэгт ажилдаа хайнга хандаж өмнөх аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй алдаа, зөрчлийг давтан гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах 2 саналыг аймгийн Засаг даргад хүргүүлээд байна.



Аудитаас өгсөн албан шаардлага зөвлөмжийн мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлснээр орон нутгийн хөрөнгө оруулалтыг эдийн засгийн тооцоо, судалгаа, зураг төсөвт үндэслэн нэн шаардлагатай хөрөнгө оруулалтыг төлөвлөх, санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгох, бий болсон хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зэргээр орон нутгийн хөрөнгө оруулалтын олон нийтийн хүртэх үр өгөөж нэмэгдэх үр дүнг бий болох юм.

➤ **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД АЖЛЫН БАЙР НЭМЭГДСЭН БАЙДАЛ**

Төрийн аудитын газрын өөрийн төлөвлөгөөний дагуу аудитыг гүйцэтгэлээ. ХЭДСангаас 2018 онд 3867 хүн хамруулж 1503.7 сая төгрөг зарцуулснаас 194 иргэнд 900.0 сая төгрөг, 2019 онд 3890 хүн хамруулж 1661.8 сая төгрөг зарцуулснаас 160 иргэнд 787.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгосон байна. үүний дүнд 2018 онд 1408, 2019 онд 1502 ажлын байр шинээр бий болжээ.

Аудитаар ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний төсвийг зориулалтын дагуу зарцуулсан ч сургалтын байгууллагуудтай байгуулсан гэрээг дүгнээгүй, Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь ХЭҮЗ-ийн баталсан хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, үр нөлөөг тооцох эрх, үүргээ хэрэгжүүлээгүй, Сургалтад хөрөнгө зарцуулж байгаа боловч эцсийн үр дүн болох ажилгүй иргэн ажилтай болсон байх асуудал орхигдсон, Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн байдалд байгууллагын дотоод хяналт, шалгалт хийсэн боловч түүний мөрөөр үр дүнтэй арга хэмжээ аваагүй зэрэгтэй холбоотой нийт 324.6 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрсэнд төвлөрүүлэх арга хэмжээ авах 1, зөрчлийг арилгах, таслан зогсоох 1, нийт 2 албан шаардлага, 9-н заалт бүхий зөвлөмж хүргүүлэн биелэлтийг бүрэн хангуулж ажиллалаа.

Аудитаас **“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангаас санхүүжүүлсэн төслүүд хэрэгжиж байгаа боловч төлөвлөсөн ажлын байрыг хангалттай бий болгоогүй байна”** гэсэн дүгнэлт өглөө.

➤ **СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХЯНАЖ ДҮГНЭЛТ ГАРГАХ**

Аймаг нийслэл сум дүүргийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд аудитыг хийж аудитын тайланг аймгийн Сонгуулийн хооронд хүргүүлээ. Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс 514984.8 мянган төгрөгийн санхүүжилт ирснээс 506323.3 мянган төгрөгийг АНСДИТХСонгуулийн тухай хууль болон СЕХ ны чиглэл удирдамжийн дагуу зардлыг эдийн засгийн ангиллаар хуваарилан зарцуулсан байна.



➤ **БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТӨСВӨӨС ОЛГОСОН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ:**

Байгаль хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийх аудитын төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хийгдэж байгаа бөгөөд аудитын тайлагналын үе шатны ажлууд хийгдэж байна. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 2018 онд 35 арга хэмжээнд 469.2 сая төгрөг, 2019 онд 25 арга хэмжээнд 407.2 сая төгрөгийн санхүүжилт олгож зарцуулсан байна. Одоогийн байдлаар хөрөнгийн зарцуулалт, худалдан авах ажиллагаа, төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнд холбогдох баримт материалуудыг шалгаж бүрэн дууссан бөгөөд илрүүлэлтийг нэгтгэж шалгадагч байгууллагын удирдлага, холбогдох албан тушаалтнуудад танилцуулах, санал тайлбарыг авах ажлыг хийж байна.

Аудитын дүнд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуулиар тодорхойлсон хэмжээний хөрөнгийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах, улмаар хөрөнгийг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, төсөл арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнд байгалийн нөөц нэмэгдэх, нөхөн сэргээгдэх, олон нийтийн хүртэх үр ашиг дээшлэх зэрэг эдийн засгийн болон экологийн үр өгөөж бий болно гэж төлөвлөж байна.

➤ **“ АЙМАГ НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮРГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛИЙН ТОЙРОГТ НАМ ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧЭЭС ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭ ТОГТООХ ”**



Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, АНСДИТХСТухай хуулийн дагуу сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтоох дүн шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэлээ. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох дүн шинжилгээний ажлыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 6 дугаар 10-ны өдрийн а/52 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу холбогдох газруудаас албан бичгээр үнийн саналыг авч тооцооллыг хийж улс төрийн намуудад хүргүүлэн, зардлын дээд хэмжээг хуульд заасан хугацаанд нийтэд мэдээллээ.

➤ **“ЦӨМ СҮРГИЙН ҮРЖЛИЙН ТӨВ” ОНӨААТҮГ-ЫН 2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ДАХЬ ӨМЧ ХӨРӨНГИЙН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН БАЙДАЛ” - ЭРСДЭЛИЙН АУДИТ**

Эрсдэлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудитын дүнд үндэслэн Төрийн аудитын газрын өөрийн санаачилгаар Цөм сүргийн үржлийн төв ОНӨААТҮГ-ын 2019 оны биологийн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт, үржлийн мал захиалгаар нийлүүлэх, түрээслүүлэх болон бусад гэрээ, гэрээний үүргийн биелэлтийн талаар шалгасан. Аудитын явцад Цэнхэр, Төвшрүүлэх, Эрдэнэмандал сумын нутагт



байрлаж байгаа ЦСҮТ-ын мал амьтдыг тооллогод хамруулж, ОНХС-аас ЦСҮТ-өөр дамжуулан олгосон 100.0 сая төгрөгийн санхүүжилтийн зарцуулалт, үр дүнгийн талаар уулзалт ярилцлага зохион байгуулж ажиллалаа.

Аудитаар нийт **100.0** сая төгрөгийн зөрчил илэрснээс **21.5** сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, **78.5** сая төгрөгийн зөрчилд гэрээний хугацаа болон эргэн төлөлтийг байгууллага бүрийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан нэмэлт өөрчлөлт оруулах 1 заалт, байгууллагын үйл ажиллагаа, дотоод хяналттай холбоотой 3 заалт бүхий зөвлөмжийг Цөм сүргийн үржлийн төв болон аймгийн ОНӨГ-т хүргүүлснээс **88.0** сая төгрөгийн зөрчил дутагдал бүрэн арилж, **12.0** сая төгрөгийн төлбөрийн актын биелэлтийн хэрэгжих хугацаа болоогүй дүнтэй байна.

Аудитын дүнгээс **“Үржлийн мал худалдан авсан гэрээний нөхцөл хангалтгүйгээс үр дүнг тооцох боломжгүй байна”** гэсэн дүгнэлт өгсөн.

➤ **“АРХАНГАЙД ҮЙЛДВЭРЛЭВ” ОНӨААТҮГ-ЫН 2019 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА – ЭРСДЭЛИЙН АУДИТ**

Төрийн аудитын газрын өөрийн санаачилгаар санхүүгийн тайлангийн аудитын дүнд үндэслэн Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ газрын 2019 оны бизнес төлөвлөгөө, үр ашигт ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, тайлагналын байдалд эрсдэлийн аудит хийсэн. Аудитаар тус байгууллагын бизнес төлөвлөгөө, орлого бүрдүүлэлт, зардлын зарцуулалт, түрээслэгч нартай байгуулсан гэрээ, аймгийн засаг даргатай байгуулсан гэрээ, урсгал зардал, үндсэн хөрөнгө, дотоод хяналтыг шалгаж **“Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ газар нь холбогдох хууль, эрх зүйн актуудыг мөрдөөгүй, алдагдалтай ажилласан байна”** гэсэн дүгнэлтийг хийсэн.

Аудитаар **46.1** сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, **5.6** сая төгрөгийн алдааг бүртгэл тайланд залруулж, **0.4** сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоон, **37.4** сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгуулах 7 албан шаардлага, **2.7** сая төгрөгийн зөрчилд **8** заалт бүхий зөвлөмжийг тус тус хүргүүлж биелэлтийг бүрэн хангуулаад байна.

➤ **ЗАВСАРЫН АУДИТ**

Санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн үе шат болох завсрын аудитад 203 байгууллагыг хамруулахаас 124 байгууллагын аудитын төлөвлөлтийн шатны ажлуудыг бүрэн хийлээ. Тайлангийн жилийн эцэс 12-р сард 79 байгууллагын төлөвлөлтийн үе шатны ажлыг бүрэн хийж дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. САБ-ийн аудиторууд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөөт “Төрөөс ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн”, “Аймаг, сум ИТХ-ийн 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт”, “Аймаг, сум ИТХ-ийн 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл” зэрэгт аудит хийсэн тул завсрын аудит хугацаа хойшилсон байна.



➤ “АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ ХӨРӨНГИЙГ ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН ЗАРЦУУЛАЛТ”

Төрийн аудитын газрын өөрийн төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2018, 2019 оны зарцуулалтад нийцлийн аудитыг хийлээ. Аудитаар Засаг даргын нөөц хөрөнгийг журамд нийцүүлэн зарцуулаагүй, зардлын тооцоог холбогдох хэлтсээр хянуулаагүй, зөвлөлд танилцуулаагүйтэй холбоотой нийт **85.6** сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, **19.8** сая төгрөгийн зөрчилд 4 заалт бүхий зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлж, биелэлтийг тооцож ажиллалаа.

Аудитын дүнд үндэслэн дараах саналыг гаргаж ҮАГ-т хүргүүлж ажиллалаа. Үүнд:

1. Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг журамд нийцүүлэн зарцуулсан эсэхэд улсын хэмжээнд нэгдсэн байдлаар аудит хийж нөөц хөрөнгийг журамд заасан нийтлэг үндэслэлийн дагуу **урьдчилан төлөвлөж, төсөвт тусгах боломжгүй** зардлуудад зарцуулж байхаар журмын зүйл заалтад өөрчлөлт оруулж, шинэчлэх шаардлага байгаа нь энэхүү аудитаас ажиглагдлаа. Өөрөөр хэлбэл нөөц хөрөнгө журамд заасан зориулалтын дагуу зарцуулагдах байдал жилээс жилд буурч бусад хууль, журмаар зохицуулагдах арга хэмжээний зардлыг нөөц хөрөнгөөс зарцуулж байна. Тухайлбал: “Үндэсний их баяр наадмын тухай хууль”-ийн 13.1.3-т “*Баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах төсвийг тухайн шатны ИТХ-аар батлуулан зарцуулах*” гэсэн заалтын дагуу баяр наадмын зардлыг, Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын 2-т “*Мал тооллоготой холбогдон гарах зардлыг ...бүх шатны засаг даргын тамгын газрын жил бүрийн төсөвт тооцон тусгаж, санхүүжүүлэхийг .. бүх шатны засаг даргад үүрэг болгосугай*” гэсэн заалтын дагуу мал тооллогын зардлыг, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.9-д заасны дагуу цэрэг татлагын зардлыг тус тус холбогдох хууль, тогтоолын дагуу шийдвэрлэж зарцуулдаг байх.
2. 2018, 2019 онд нийт хөрөнгийн 12.4 хувь буюу 60.1 сая төгрөгийг гаднын зочид төлөөлөгчдийг хүлээн авах буудал, хоолны зардалд, 6.8 хувь буюу 33.2 сая төгрөгийг арга хэмжээ зохион байгуулах хүнс, бараа материалын зардалд зарцуулсан нь нөөц хөрөнгийг **урсгал зардалд** их хэмжээгээр зарцуулах нөхцөл байдал үүссэн байна. Иймээс нэгдсэн төлөвлөгөөт аудитыг хийж улсын хэмжээнд урьдчилан төлөвлөж, төсөвт тусгах боломжтой зардлуудыг шийдвэрлэх, журмын хэрэгжилтийг хангуулан ажиллах.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ДОТООД АЖЛЫН ТАЛААР

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ :

- ❖ Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас Төсвийн тухай хууль болон Төрийн аудитын тухай хуулийн 6.3.2 ” аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, аймаг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх” гэсэн заалтын дагуу орон нутгийн 2021 оны төсвийн төсөлд 3-н төрлийн орлогыг 1657.8 сая

төгрөгөөр нэмэгдүүлэх, үр ашиг дээшлүүлэх 11 саналыг аймгийн ИТХ-д хүргүүлснээс орон нутгийн төсвийн орлогыг 200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, үр ашиг дээшлүүлэх саналыг хүлээн авсан тухай аймгийн ИТХ-ын 2020.12.09-ны 115 тоот албан бичгийг ирүүлээд байна.

ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ХҮРЭЭНД :



ТАГ-2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу аудитуудаас мэргэжлийн сургалтын хэрэгцээ, шаардлагын судалгааг авч саналыг нэгтгэн СУГ-т хүргүүлэн, ТАБ-ын 2020 оны сургалтын төлөвлөгөөнд тусгууллаа. Сургалтын хүрээнд Ахлах аудитуудын сургалтад 3, Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох сургалтад 5 нийт 8 ажилтан онлайн сургалтад амжилттай хамрагдаад байна.

Аудитуудын сургалтын хэрэгцээ шаардлагад үндэслэн Тэргүүлэх аудиторовын 2020 оны А/04 тоот тушаалаар “ ТАГ-ын 2020 оны Мэргэжлийн тасралтгүй сургалтын төлөвлөгөө”-г батлан хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулан ажиллаж байна. Мэргэжлийн тасралтгүй боловсролын сургалтын төлөвлөгөөний дагуу “Хувь хүний хөгжил”, “Багийн менежмент” “Хувь хүний харилцаа, хандлага” сургалтуудыг аймгийн Насан туршийн боловсролын төвтэй гэрээ байгуулан сургагч багш нараар сургалтыг зохион байгуулж, Төрийн аудитын байгууллагын ёс зүйн дүрмийн сургалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулав.

- ❖ 2020 онд ТАБ-аас дэвшүүлсэн “Төрийн аудитын эрх зүйн орчин, стандартын шинэтгэлийн жил” зорилтын хүрээнд Нийцлийн аудитын багаас ажилтнуудыг ажлаа хийнгээ хууль, журмыг сонсох, судлах боломжийг нь хангах үүднээс
- ❖ Төрийн аудитын тухай шинэчлэгдсэн хууль, Төрийн аудитын байгууллагын ажилтны мөрдөх ёс зүйн дүрмийг аудио хэлбэрт шилжүүлэн **абле** системийн мэдээллийн санд байршууллаа.
- ❖ Төрийн аудитын байгууллагын ажилтны мөрдөх ёс зүйн дүрэм сонсох

холбоос: <https://www.youtube.com/watch?v=zbRU8herlmQ&t>

Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг сонсох холбоос:
https://www.youtube.com/watch?v=iU4So6P_gxM&feature=youtu.be

- ❖ Байгууллагын дотоод ажлын төлөвлөгөө болон цаг үеийн байдалтай уялдуулан “Хариу нэхээгүй тус” ажлын хүрээнд хамт олны хуримтлалын сангаас 0.3 сая төгрөгийн хүнсний материалаар зорилтод бүлгийн 4 өрхөд тусламж үзүүллээ.



- ❖ 2020 онд Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын онлайн сургалтын системийг ахлах аудитор Б. Азхүү санаачлан туршилтаар хийж нэвтрүүлсэн. Холбоос: <https://arkhangai.teachable.com/>

ДОТООД АЖЛЫН ТАЛААР :

2020 онд байгууллагын дотоод үйл ажиллагааны хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Байгууллагын бүх ажилтнуудаар ХАСХОМ ийг хуульд заасан хугацаанд гаргууллаа.
- ❖ ТАГ-ын ажилтнууд ёс зүйн хэм хэмжээг сахих, ашиг сонирхлын зөрчилд орохгүй байх, гэмт хэрэг зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх үүднээс аудит бүрийн эхэнд ажилтнуудаас ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг гаргуулан авч баримтжуулж байна.
- ❖ Өргөдөл, хүсэлт 46 ирснээс ажилтнуудын чөлөө хүссэн дотоод өргөдөл 16, хуулийн байгууллага болон ТАСЗ-д уламжлах 1, аудиттай холбоотой 26, аудитортай холбоотой 2 өргөдөл, ажилд орох хүсэлт 1 ирсэн байна. Ирсэн өргөдөл, хүсэлтийг цаг тухайд нь шийдвэрлэж ажиллалаа.
- ❖ Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирсэн албан бичиг 625, YAГ-аас 29, бусад байгууллагаас 596 ирсэн, үүнээс хариутай бичиг 45, шийдвэрлэсэн нь 45 байна. Ирсэн бичиг бүрийг цаг тухайд нь танилцуулан холбогдох ажилтнуудад шилжүүлэн, хариуцсан хүнээр гарын үсэг зуруулж, бүртгэл хөтлүүлэн, шийдвэрлэлтэнд хяналт тавин ажиллаж байна. Мөн хугацаанд нийт 541 албан бичиг гарснаас 43 нь YAГ-т, бусад нь гадны албан байгууллагуудад тараагдсан байна. Үүнээс 147 нь хариутай, хариу ирсэн нь 142, хугацаа болоогүй 5, хугацаа заагаагүй буюу огт хариу ирээгүй албан бичиг байхгүй байна. Ирсэн, явсан бичиг, акт, албан шаардлага, зөвлөмж,

гэрчилгээнүүдийг тухай бүрт нь скайнердаж, 2018, 2019, 2020 оны файлын санг үүсгэн архивлаж, баримт бичгүүдийг цахим хэлбэрт орууллаа.

- ❖ Байгууллагын 2020 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг Тэргүүлэх аудиторын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/02 дугаар тушаалаар батлуулан мөрдөж ажиллаж байна. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу санхүүгийн аудитын 192, гүйцэтгэлийн аудитын 23, нийцлийн аудитын 12 мемориал ажлын баримтыг, мөн байгууллагын 2019 оны санхүүгийн баримт материал 11, 2019 оны ирсэн, явсан бичгийн 10, тушаал шийдвэрийн 2, 2020 оны ирсэн явсан бичгийн 9, тушаал шийдвэрийн 2, удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэл 1 баримтыг хадгаламжийн нэгж болгон байгууллагын архивд нийт 261 мемориал баримтыг хүлээн авч хадгаламжийн нэгж болгон байгууллагын архивд хадгаллаа.
- ❖ Байгууллагын санхүүгийн 2019 оны санхүүгийн тайланд “ Гранд Тронтон-Аудит “ ХХКомпаниар аудит хийлгэж “Зөрчилгүй” санал дүгнэлтийг авлаа.

- ❖ Төрийн аудитын газар 2020 оны аудитын төлөвлөгөөний дагуу "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт" сэдэвт нийцлийн аудитын төлөвлөгөө, нээлт, аудитын явц, илрүүлэлтийг сумдын удирдлага, холбогдох албан тушаалтнуудад онлайн танилцууллаа.



- ❖ олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулж “Хөгжөөнт” тэмцээнийг дотооддоо зохион байгууллаа.

- ❖ Эх үрсийн баярыг тохиолдуулан бяцхан үрсдээ болон ээжүүдэд гарын бэлэг гардууллаа. Шинээр төрсөн 4 хүүхэд тус бүрд Хас банкны 50,0 мянган төгрөгийн хадгаламжийг нээж өглөө.

- ❖ Байгууллагын дотоод ажлын төлөвлөгөөний дагуу байгууллагын ажилтнуудыг 634.0 мянган төгрөгийн эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулав.
- ❖ Аймгийн ИТХ-ын ажлын алба, ЗДТГ-аас зохион байгуулсан “Шилжин явах цом”-ын төлөөх спортын төрлийн тэмцээнд амжилттай оролцлоо.





- ❖ Байгууллагын ажилчдыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлж долоо хоног бүрийн нэг дэх өдөр спорт заалыг авч гар бөмбөг болон бусад спортоор хичээллэхэд нь анхаарч ажиллаж байна. Бүх нийтийн цас, хог цэвэрлэгээнд хамт олноороо нийгмийн ажилд идэвхтэй оролцлоо.
- ❖ Ахмадын баяраар байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан 4 ахмадад 400.0 мянган төгрөгийн хүндэтгэл үзүүллээ.
- ❖ 2020 онд Чанарын баталгаажуулалтын албанаас хийсэн санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитыг шалгаж, зөвлөмж ирүүлсний дагуу илрүүлэлтийн бүртгэлд үндэслэн цаашид анхаарах асуудлын талаар видео танилцуулга бэлтгэн абле системд байршуулан бүх ажилтнуудад танилцуулж ажиллалаа.

ДОЛООДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Байгууллагын санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг санхүүгийн UNICUS программаар хийж гүйцэтгэж байгаа бөгөөд санхүүгийн улирал, хагас бүтэн жилийн тайлан балансыг холбогдох хууль, журмын дагуу гаргаж байна.

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар 2020 онд 462.9 сая төгрөгийн санхүүжилт ирснийг хөтөлбөр, арга хэмжээ, зориулалтын дагуу 449.9 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийн хүрээнд санхүүгийн гүйлгээг хийж төсвийг зориулалтын дагуу зарцуулж, байгууллагуудтай тооцоо нийлж өглөг авлагагүй ажиллалаа.

Байгууллагын санхүү, төсвийн зарцуулалтын тайлан, мэдээг сар бүр YAГ-ын Тамгын газарт хүргүүлж байгууллагын шилэн данс болон мэдээллийн самбарт байршуулав. Мөн төсвийн тухай хуулийн дагуу байгууллагын 2021 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төслийг боловсруулж YAГ-т хүргүүллээ.

Нэмэлт орлогын санхүүжилтийн дансанд 2020 онд аудитын үйлчилгээний хөлсний орлогоор 79.5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлээд байна.

ТӨБЗГ-ын 2020 оны А-1/1705, 484 дугаар тогтоол, YAГ ын 03/3045 тоот албан бичгээр зөвшөөрөл олгосны дагуу дээрх 8,3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 102.9 сая төгрөгийн балансын үнэ бүхий 2 ширхэг автомашиныг холбогдох хууль журмын дагуу дуудлага худалдаа зохион байгуулан бүртгэл данснаас хаслаа.

Шилэн дансны тухай хуулийн шилэн дансны цахим системд нийт 151 мэдээлэл байршуулсан байна.



НАЙМДУГААР БҮЛЭГ. САНАЛ ДҮГНЭЛТ

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар Үндэсний аудитын газраас дэвшүүлсэн **“Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин, стандартын шинэтгэлийн жил”** зорилтын хүрээнд 2020 оныхоо гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа

Байгууллагын 2020 онд хийхээр төлөвлөгдсөн аудитаас гүйцэтгэлийн 1 аудит төлөвлөгдсөн хугацаанд бүрэн хэрэгжээгүй болно.

Хийгдсэн аудитын тухайд зарим нэг хүндрэл бэрхшээл гарч байсныг товч дурдвал:

Хүний нөөцийн дутагдалтай байлаа.

- Санхүүгийн тайлангийн аудитад хараат бус хуулийн этгээдийг оролцуулахаар төлөвлөсөн ч гүйцэтгэгч санал ирүүлээгүй, мөн Төрөөс бүх нийтийн боловсрол олгож байгаа өнөөгийн байдал сэдэвт аудитын хамрах хүрээ хэт өргөн байсан бөгөөд бид өөрсдийн хүчээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүний дүнд нэг аудиторын ажлын ачаалал хэт ихсэж, хүн хүний нөөц хүрэлцээ дутагдсан, аудитыг бүрэн хэмжээнд хийхэд цаг хугацаа хязгаарлагдаж байсан бөгөөд санхүүгийн аудиттай зэрэгцээд нэгдсэн төлөвлөгөөт аудитууд хийгдэж эхэлсэн зэрэг хүндрэлүүд гарч байлаа. Иймд хуулийн дагуу хийгдэх аудитыг хугацаанд нь чанартай хийхийн тулд хүний нөөцийн асуудлыг хүрэлцээтэйгээр шийдвэрлэхэд анхаарна уу.

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР